



## НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 30 өдөр

Дугаар А/109

Улаанбаатар хот

### Захиалагчийн хяналт тавих тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.4, 63.1.5 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, мөн зүйлийн 14.4 дэх хэсэг, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.6 дахь заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 24/33 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2025 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хавсралтаар баталж, 1 дүгээр хавсралтаар баталсан төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналт тавьж ажиллахыг “Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ (Б.Мөнхбат)-т, 2 дугаар хавсралтаар баталсан төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Замын хөгжлийн газар (Б.Одбаяр)-т, 3 дугаар хавсралтаар баталсан төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналт тавьж ажиллахыг “Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж” ОНӨТҮГ (У.Баатар)-т, 4 дүгээр хавсралтаар баталсан төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналт тавьж ажиллахыг Сонгинохайрхан дүүргийн Засаг дарга (Ц.Баттөр)-т, 5 дугаар хавсралтаар баталсан төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Эрүүл Мэндийн Газар (П.Эрхэмбулган)-т тус тус үүрэг болгосугай.

2. Захирамжийн хавсралтад заасан төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг гүйцэтгэлээр нь холбогдох хууль, журмын дагуу хянан баталгаажуулж, санхүүжилтийн эрх нээхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын Хөрөнгө оруулалтын хэлтэс (Б.Гантулга)-т, нээсэн эрхийг үндэслэн батлагдсан төсвийн сар, улирлын хуваарийн дагуу санхүүжүүлэхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Л.Эрдэнэбадрах)-т, хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийг нийслэлийн өмчид бүртгэн авч, эзэмшилт, ашиглалтад нь хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар (В.Оюумаа)-т тус тус даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар ханган ажиллахыг Нийслэлийн Засаг даргын эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Т.Даваадалайд даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН  
ЗАХИРАГЧ

Х.НЯМБААТАР



1725020486

Нийслэлийн Засаг даргын 2025 оны  
 01 дүгээр сарын 30 ны өдрийн  
 А/10.9 дугаар захирамжийн  
 1 дүгээр хавсралт

НИЙСЛЭЛИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР 2025 ОНД САНХҮҮЖҮҮЛЭХ  
 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

| Д/д | Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил                                                                   | Хугацаа |        | Төсөвт өртөг | 2025 онд санхүүжих дүн |
|-----|-------------------------------------------------------------------------------------------------------------------|---------|--------|--------------|------------------------|
|     |                                                                                                                   | Эхлэх   | Дуусах |              |                        |
| 1   | Эрүүл мэндийн төвийн цогцолбор /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 24 дүгээр хороо/                                    | 2022    | 2026   | 9,891.1      | 6,100.0                |
| 2   | Аддиктологийн төвийн барилга /Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20 дугаар хороо/                                   | 2022    | 2026   | 32,709.3     | 12,631.6               |
| 3   | Хороо, өрхийн эмнэлэг, цагдаагийн хэсгийн цогцолбор барилга (Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 36 дугаар хороо) | 2024    | 2025   | 3,300.0      | 1,650.0                |
| 4   | Хороо, өрхийн эмнэлэг, цагдаагийн хэсгийн цогцолбор барилга (Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 37 дугаар хороо) | 2024    | 2025   | 3,300.0      | 1,650.0                |
| 5   | Хороо, өрхийн эмнэлэг, цагдаагийн хэсгийн цогцолбор барилга (Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 35 дугаар хороо)   | 2024    | 2025   | 4,200.0      | 851.6                  |
| 6   | Цэцэрлэгийн өргөтгөлийн барилга, 150 ор (Баянзүрх дүүрэг, 18 дугаар хороо, 129 дүгээр цэцэрлэг )                  | 2022    | 2025   | 5,012.8      | 1,813.7                |
| 7   | Цэцэрлэгийн барилга, 240 ор /Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 29 дүгээр хороо/                             | 2022    | 2025   | 4,197.0      | 2,797.0                |
| 8   | Цэцэрлэгийн барилга, 240 ор /Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 16 дугаар хороо/                                    | 2022    | 2025   | 6,128.1      | 301.9                  |
| 9   | Бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор /Сонгинохайрхан дүүрэг, 32 дугаар хороо/                                     | 2022    | 2025   | 4,376.7      | 3,576.8                |
| 10  | Бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор /Сонгинохайрхан дүүрэг, 32 дугаар хороо/ нэмэлт                              | 2022    | 2025   | 1,755.8      | 1,755.8                |
| 11  | Бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор (Хан-Уул дүүрэг, 24 дүгээр хороо)                                            | 2024    | 2025   | 6,291.6      | 3,341.6                |
| 12  | Сургуулийн барилга, 640 суудал /Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 8 дугаар хороо/                                | 2020    | 2026   | 13,356.3     | 4,000.0                |
| 13  | Сургуулийн барилга, 960 суудал /Улаанбаатар хот, Хан-уул дүүрэг, 4 дүгээр хороо/                                  | 2022    | 2025   | 11,982.6     | 6,291.3                |

|    |                                                                                                                                             |      |      |          |          |
|----|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------|------|----------|----------|
| 14 | Сургуулийн барилга, 960 суудал /Улаанбаатар хот, Хан-уул дүүрэг, 4 дүгээр хороо/ нэмэлт                                                     | 2022 | 2025 | 6,605.6  | 5,605.6  |
| 15 | Сургуулийн барилга, 640 суудал /Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 16 дугаар хороо/                                                           | 2022 | 2025 | 15,323.2 | 5,475.6  |
| 16 | Сургуулийн барилга, 640 суудал /Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 12 дугаар хороо/                                                          | 2022 | 2025 | 16,765.9 | 10,765.9 |
| 17 | Сургуулийн барилга, 640 суудал /Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 30 дугаар хороо/                                                    | 2022 | 2025 | 9,705.3  | 5,305.3  |
| 18 | Сургуулийн барилга, 640 суудал (Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 14 дүгээр хороо)                                                          | 2022 | 2025 | 9,975.3  | 5,575.3  |
| 19 | Сургуулийн барилгын өргөтгөл, 640 суудал /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 62 дугаар сургууль/                                           | 2018 | 2025 | 10,673.6 | 2,158.0  |
| 20 | Сургуулийн барилга, 960 суудал (Улаанбаатар хот, Хан-уул дүүрэг, 23 дугаар хороо)                                                           | 2024 | 2026 | 17,992.6 | 6,496.3  |
| 21 | Сургуулийн өргөтгөлийн барилга, 320 суудалтай (Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 21 дүгээр хороо, 127 дугаар сургууль)                      | 2024 | 2026 | 6,500.0  | 2,550.0  |
| 22 | Сургуулийн барилга буулгаж шинээр барих, 960 суудал (Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 30 дугаар сургууль)                                  | 2024 | 2026 | 16,698.0 | 5,690.0  |
| 23 | Сургуулийн барилга (Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 16 дугаар хороо, Гандантэгчэнлин хийд)                                                 | 2024 | 2025 | 7,772.1  | 3,886.0  |
| 24 | Сургуулийн барилга, 960 суудал /Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 24 дүгээр хороо/                                                           | 2024 | 2026 | 18,000.0 | 5,000.0  |
| 25 | Сургуулийн барилга, 960 суудал /Улаанбаатар хот, Хан-уул дүүрэг, 17 дугаар хороо/                                                           | 2024 | 2026 | 17,077.5 | 5,000.0  |
| 26 | Сургуулийн барилга, 640 суудал /Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 36 дугаар хороо/                                                          | 2024 | 2026 | 14,800.0 | 5,000.0  |
| 27 | 23 дугаар сургуулийн спорт заалыг буулгаж, усан бассейн бүхий спорт заал шинээр барих (Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг)                   | 2024 | 2026 | 7,250.1  | 2,515.0  |
| 28 | 37 дугаар сургуулийн спорт заалыг бассейн бүхий спорт заал шинээр барих (Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг)                                 | 2024 | 2026 | 7,286.4  | 2,533.1  |
| 29 | Улаанбаатар хотын бохир усны "Туул-1" коллекторын 4 дүгээр хэсгийн 1 дүгээр ээлжийн 5.4 км шугамын барилга угсралтын ажил /Улаанбаатар хот/ | 2019 | 2025 | 6,190.3  | 350.0    |
| 30 | Соёлын ордны барилга /Улаанбаатар хот, Багахангай дүүрэг, 1 дүгээр хороо/                                                                   | 2020 | 2026 | 5,152.2  | 800.0    |

|    |                                                                                                                                                                                                                 |      |      |          |          |
|----|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------|------|----------|----------|
| 31 | Хойд жигүүрийн халаалт болон хэрэглээний халуун усны шугам сүлжээ (Багахангай дүүрэг, 1 дүгээр хороо)                                                                                                           | 2024 | 2025 | 545.6    | 395.6    |
| 32 | Баянзүрх дүүргийн 13, 14 дүгээр хороо, Орон сууцны XIV хороолол орчмын Е хэсэгчилсэн талбайн гадна цахилгаан хангамжийн барилга угсралтын ажил                                                                  | 2019 | 2025 | 3,033.4  | 76.1     |
| 33 | 14 дүгээр хороолол, "И" хэсэгчилсэн талбайн гэр хорооллын дахин төлөвөлөлтийн инженерийн дэд бүтцийн гадна цахилгаан хангамж, холбооны шугам сүлжээ (Баянзүрх дүүрэг, 13 дугаар хороо)                          | 2022 | 2025 | 3,574.8  | 200.0    |
| 34 | Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай 36А, 36Б дугаар орон сууцны барилгыг буулган барилгажуулах төслийн гадна инженерийн шугам сүлжээний ажил (Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 11 дүгээр хороо) | 2024 | 2025 | 3,497.2  | 2,497.2  |
| 35 | Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай Арьс ширний 31 дүгээр орон сууцны барилгыг буулган барилгажуулах төслийн гадна инженерийн сүлжээний ажил (Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 20 дугаар хороо) | 2024 | 2025 | 1,436.3  | 436.3    |
| 36 | Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай 27 дугаар орон сууцны барилгыг буулган барилгажуулах төслийн гадна инженерийн сүлжээний ажил (Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 6 дугаар хороо)            | 2024 | 2025 | 1,436.9  | 436.9    |
| 37 | Багц1 "Сэлбэ сэргэлт" төслийн Сэлбэ-Дунд голын үерийн хамгаалалтын барилга байгууламжийн угсралт (БЗД, 43 дугаар хороо, СБД, 1-р хороо, I ээлж ПК18+00-ПК25+33)                                                 | 2024 | 2025 | 19,594.0 | 10,594.0 |
| 38 | Багц 3 Чингэлтэй дүүргийн Үерийн хамгаалалтын барилга байгууламж (ЧД, 7, 10, 12, 16, 17 хороо, I ээлж I, II суваг)                                                                                              | 2024 | 2025 | 3,316.9  | 1,223.9  |
| 39 | Багц 2 Арцат, Нүхт, Морь барьдагийн ам, уяачдын хотхоны үерийн хамгаалалтын барилга байгууламж (ХУД, 4,5,6,7,8 дугаар хороо)                                                                                    | 2024 | 2025 | 14,083.0 | 12,083.0 |
| 40 | Гэрэлтүүлгийн тоног төхөөрөмж (Улаанбаатар хот, Багануур дүүрэг)                                                                                                                                                | 2024 | 2025 | 1,475.9  | 711.4    |
| 41 | Геологийн төв лабораторийн уулзвараас офицеруудын ордны тойрог хүртэл 11,6 км нийтийн эзэмшлийн явган хүний зам,                                                                                                | 2024 | 2025 | 8,055.6  | 3,222.2  |

|     |                                                                                                                                                                                                     |      |      |           |           |
|-----|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------|------|-----------|-----------|
|     | талбайн тохижилтын ажил, 1 дүгээр хэсэг (Улаанбаатар хот, ЭТӨЧ, Москвагийн гудамж)                                                                                                                  |      |      |           |           |
| 42  | Геологийн төв лабораторийн уулзвараас офицеруудын ордны тойрог хүртэл 11,6 км нийтийн эзэмшлийн явган хүний зам, талбайн тохижилтын ажил, 2 дугаар хэсэг (Улаанбаатар хот, ЭТӨЧ, Москвагийн гудамж) | 2024 | 2025 | 7,243.7   | 3,621.8   |
| 43  | Геологийн төв лабораторийн уулзвараас офицеруудын ордны тойрог хүртэл 11,6 км нийтийн эзэмшлийн явган хүний зам, талбайн тохижилтын ажил, 3 дугаар хэсэг (Улаанбаатар хот, ЭТӨЧ, Москвагийн гудамж) | 2024 | 2025 | 9,008.3   | 3,456.3   |
| 44  | Геологийн төв лабораторийн уулзвараас офицеруудын ордны тойрог хүртэл 11,6 км нийтийн эзэмшлийн явган хүний зам, талбайн тохижилтын ажил, 4 дүгээр хэсэг (Улаанбаатар хот, ЭТӨЧ, Москвагийн гудамж) | 2024 | 2025 | 4,675.9   | 1,870.4   |
| 45  | Нийтийн эзэмшлийн явган хүний зам, талбайн тохижилтын ажил, Чингисийн өргөн чөлөө 1 дүгээр хэсэг                                                                                                    | 2024 | 2025 | 3,268.4   | 2,287.9   |
| 46  | Нийтийн эзэмшлийн явган хүний зам, талбайн тохижилтын ажил, Чингисийн өргөн чөлөө 2 дугаар хэсэг                                                                                                    | 2024 | 2025 | 2,721.4   | 1,905.0   |
| 47  | Нийтийн эзэмшлийн явган хүний зам, талбайн тохижилтын ажил, Сүхбаатарын талбай орчмын явган зам                                                                                                     | 2024 | 2025 | 1,166.5   | 108.3     |
| 48  | Нийтийн эзэмшлийн явган хүний зам, талбайн тохижилтын ажил, Олимпын гудамж, Их монгол улсын гудамж-Зүүн                                                                                             | 2024 | 2025 | 2,402.2   | 1,201.1   |
| 49  | Урт цагаан жуулчны гудамжны тохижилтын ажил (Улаанбаатар хот)                                                                                                                                       | 2024 | 2025 | 38,988.0  | 19,494.0  |
| 50  | 32-ын тойргийн үйлчилгээний барилга, тохижилт ногоон байгууламж (Улаанбаатар хот)                                                                                                                   | 2024 | 2025 | 10,089.3  | 2,866.9   |
| 51  | Нийтийн зориулалттай орон сууцны гадна фасад засвар (Улаанбаатар хот, Багануур дүүрэг, 1 дүгээр хороо)                                                                                              | 2024 | 2025 | 1,620.4   | 385.6     |
| 52  | Ус зайлуулах шугамын ажил (Сонгинохайрхан дүүрэг, 33 дугаар хороо)                                                                                                                                  | 2024 | 2025 | 2,240.6   | 1,200.0   |
| 53  | 39 дүгээр сургуулийн хос биеийн тамирын заал, усан бассейн бүхий спорт заалны барилгын ажил (Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг)                                                                     | 2024 | 2026 | 7,400.0   | 3,200.0   |
| ДҮН |                                                                                                                                                                                                     |      |      | 451,143.7 | 194,941.3 |

Нийслэлийн Засаг даргын 2025 оны  
 01 дүгээр сарын 30-ны өдрийн  
 2/109 дугаар захирамжийн  
 2 дугаар хавсралт

НИЙСЛЭЛИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР 2025 ОНД САНХҮҮЖҮҮЛЭХ  
 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

(сая төгрөг)

| Д/д | Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил                                                                              | Хугацаа |        | Төсөвт өртөг | 2025 онд санхүүжих дүн |
|-----|------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------|--------|--------------|------------------------|
|     |                                                                                                                              | Эхлэх   | Дуусах |              |                        |
| 1   | Толгойтын авто замыг Ард Аюушийн өргөн чөлөөтэй холбох авто зам, гүүрэн байгууламж, олон түвшний огтлолцол                   | 2022    | 2025   | 74,252.4     | 26,885.7               |
| 2   | Энхтайваны өргөн чөлөөний авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт (25 дугаар эмийн сангийн уулзвараас Зүүн 4 замын уулзвар) | 2024    | 2025   | 18,200.0     | 10,000.0               |
| 3   | Найрамдлын авто замын засвар, шинэчлэлт (Тахилтын уулзвараас Найрамдал зуслан )                                              | 2024    | 2025   | 20,058.9     | 10,000.0               |
| 4   | Зайсангийн төмөр бетон гүүрийн өргөтгөл, шинэчлэлт                                                                           | 2022    | 2025   | 29,716.0     | 7,916.6                |
| 5   | Эрчим хүчний гудамжны авто замын өргөтгөл, их засварын ажил (Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20 дугаар хороо)               | 2024    | 2025   | 24,335.2     | 6,415.0                |
| 6   | Нарны хорооллоос Нарны зам руу төмөр зам дээгүүр гарсан гүүрэн гарц (Улаанбаатар хот, Баянгол дүүрэг)                        | 2024    | 2025   | 2,950.9      | 1,203.1                |
| ДҮН |                                                                                                                              |         |        | 169,513.4    | 62,420.4               |

Нийслэлийн Засаг даргын 2025 оны  
07 дүгээр сарын 22-ны өдрийн  
1/109 дугаар захирамжийн  
3 дугаар хавсралт

НИЙСЛЭЛИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР 2025 ОНД САНХҮҮЖҮҮЛЭХ  
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

(сая төгрөг)

| Д/д | Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил                                   | Хугацаа |        | Төсөвт өртөг | 2025 онд санхүүжих дүн |
|-----|-----------------------------------------------------------------------------------|---------|--------|--------------|------------------------|
|     |                                                                                   | Эхлэх   | Дуусах |              |                        |
| 1   | Их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл "Метро"-г барих төслийн зөвлөх үйлчилгээ | 2024    | 2030   | 145,911.0    | 25,000.0               |
| ДҮН |                                                                                   |         |        | 145,911.0    | 25,000.0               |

Нийслэлийн Засаг даргын 2025 оны  
01 дүгээр сарын 20-ны өдрийн  
А/10.9 дугаар захирамжийн  
4 дүгээр хавсралт

НИЙСЛЭЛИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР 2025 ОНД САНХҮҮЖҮҮЛЭХ  
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

(сая төгрөг)

| Д/д | Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил                                                                                                                                   | Хугацаа |        | Төсөвт өртөг | 2025 онд санхүүжих дүн |
|-----|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------|--------|--------------|------------------------|
|     |                                                                                                                                                                                   | Эхлэх   | Дуусах |              |                        |
| 1   | Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн Цэргийн хотхон орчим ХЕТ-2013-8 багцын "А" хэсэгчилсэн талбай (Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 20 дугаар хороо) | 2022    | 2025   | 9,993.9      | 2,000.9                |
| ДҮН |                                                                                                                                                                                   |         |        | 9,993.9      | 2,000.9                |

Нийслэлийн Засаг даргын 2025 оны  
.....01... дүгээр сарын 30-ны өдрийн  
...А/109..... дугаар захирамжийн  
5 дугаар хавсралт

НИЙСЛЭЛИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР 2025 ОНД САНХҮҮЖҮҮЛЭХ  
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

(сая төгрөг)

| Д/д | Төсөл, арга хэмжээний нэр, хүчин<br>чадал, байршил                                       | Хугацаа |        | Төсөвт<br>өртөг | 2025 онд<br>санхүүжих<br>дүн |
|-----|------------------------------------------------------------------------------------------|---------|--------|-----------------|------------------------------|
|     |                                                                                          | Эхлэх   | Дуусах |                 |                              |
| 1   | Эмнэлгийн тоног төхөөрөмж<br>(Улаанбаатар хот, Сүхбаатар<br>дүүрэг, Хүрээ амаржих газар) | 2024    | 2025   | 6,098.4         | 934.1                        |
| ДҮН |                                                                                          |         |        | 6,098.4         | 934.1                        |



ለሕዝብ ጥላቻ ምክር ቤት  
 ለሕዝብ ጥላቻ ምክር ቤት



ለሕዝብ ጥላቻ ምክር ቤት

ለሕዝብ ጥላቻ ምክር ቤት ለሕዝብ ጥላቻ ምክር ቤት

ለሕዝብ ጥላቻ ምክር ቤት ለሕዝብ ጥላቻ ምክር ቤት ለሕዝብ ጥላቻ ምክር ቤት  
 ለሕዝብ ጥላቻ ምክር ቤት ለሕዝብ ጥላቻ ምክር ቤት ለሕዝብ ጥላቻ ምክር ቤት